

## Хүний эрх

### МОНГОЛ УЛСАД АЖИЛЛАЖ АМЬДАРЧ БУЙ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ ОРЧИНД АМЬДРАХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

### RIGHTS OF PEOPLE WITH DEVELOPMENTAL DISABILITIES WHO LIVE AND WORK IN MONGOLIA TO LIVE IN A HEALTHY AND SAFE ENVIRONMENT



**Н.Өнөржаргал**

*Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн Хувийн эрх зүйн  
тэнхимийн багш, хууль зүйн магистр, ахлах дэслэгч*

**Товч утга:** Монгол улсын Үндсэн хуульд заасан хүний эрхийг хангах зорилгоор иргэдийнхээ эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг улам бүр баталгаажуулах үүднээс олон улсын эрх зүйн баримт бичгүүдэд нэгдэн орох, түүнчлэн дотоодын эрх зүйн актуудад тухай бүр тусган баяжуулах арга хэмжээг тасралтгүй авч ирсэн. Хүн бүр хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс үл хамааран хууль, шүүхийн өмнө эрх тэгш байж, үндсэн эрх, эрх чөлөөгөө эдлэн, нийгмийн баялгаас адил хүртэх эрхтэй. Гэвч эдгээр хууль тогтоомжууд нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүрч үйлчилж байгаа эсэх нь эргэлзээтэй юм.

**Түлхүүр үг:** Хүний эрх, хөгжлийн бэрхшээлтэй хүн, хууль, эрх зүйн зохицуулалт, ялгаварлан гадуурхалт.

**Abstract:** In order to ensure the human rights stipulated in the Constitution of Mongolia and to ensure the right of citizens to live in a healthy and safe environment, measures are continuously taken to join international legal documents and enrich domestic legislation. Everyone, regardless of disability or not, has the right to be equal before the law and court, to enjoy basic rights and freedoms, and to enjoy the resources of society equally. But it is questionable whether these laws reach people with disabilities.

**Keywords:** Human rights, people with disabilities, law and regulation, discrimination.

Хөгжлийн бэрхшээлтэй хүнд тулгамдаж буй асуудлыг хөндсөн бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн нөхцөл байдал, ялгаварлан гадуурхах үзэгдэл, бусад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид ХБХЭ-ийн тулгамдаж буй асуудлыг Монгол Улсад хэрхэн шийдвэрлэх шаардлагатай байгаа талаар энэхүү илтгэлийн хүрээнд судлахыг зорилоо.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн бүр бусдын нэгэн адил хүний эрх, эрх чөлөөг ямар ч ялгаваргүй эдлэх явдлыг баталгаажуулах зорилгоор НҮБ-аас Оюуны хомсдолтой хүний эрхийн тухай /1971/ баталсан конвенцын хүрээнд Монгол улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тухай хууль болон актуудыг батлан гаргаж хэрэгжилтээр хангаж ирсэн байна. Хүн бүр хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс үл хамааран хууль, шүүхийн өмнө эрх тэгш байж, үндсэн эрх, эрх чөлөөгөө эдлэн, нийгмийн баялгаас адил хүртэх эрхтэй. Хүнийг хөгжлийн бэрхшээл болон эрүүл мэндийн байдлаар нь ялгаварлан гадуурхахыг хориглоно. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиар хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангаж Монгол Улсын Үндсэн хуулиар заасан эрхийг өргөжүүлэн хуульчилсан.

Энэхүү хууль тогтоомжуудын хэрэгжилт өнөөгийн Монгол улсын түвшинд хэрхэн хэрэгжиж, тэдний эрүүл аюулгүй амьдрах орчин нөхцөл хэрхэн бүрэлдэж байгаа талаар илтгэлийн хүрээнд тусгалаа.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай асуудлыг авч үзэхээс өмнө хүний эрх гэж юу вэ гэдгийг тодорхойлох хэрэгтэй байх: Хүний эрх гэдэг нь Хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш байна. Тэдэнд оюун ухаан, өрлөг сэтгэл заяасан бөгөөд өөр хоорондоо ахан дүүсийн ёсоор харилцах ёстой. Хүний эрхийн Түгээмэл тунхаглалын нэгдүгээр зүйлд “Хүний эрх бол таныг хүний зэрэгтэй амьдрахад шаардагдах наад захын баталгаа юм”. Хүмүүс ихэнхдээ амьд явах, эрүүл аюулгүй орчинд амьдрах, хөдөлмөрлөх зэрэг эрхийг л мэддэг. Гэтэл үнэндээ эдгээрээс гадна маш олон эрхийг хуулиар баталгаажуулсан.<sup>1</sup>

## **1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль түүний үзэл баримтлал**

Хөгжлийн бэрхшээлтэй хүн ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн тухай Хүний эрхийг дээдлэх нь ардчилсан нийгмийн оршин тогтнох үндэс суурь юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрүүл аюулгүй тав тухтай

---

<sup>1</sup><https://www.legalinfo.mn/details/480>

амьдах эрхийн хуульчилж өгөх улс үндэстэн хөгжихийн үндэс юм. Хүний эрхийн гол зарчим бол хүний бие, сэтгэл, соёлын болон нийгмийн ялгаанаас үл хамааран бүх хүнд адил тэгш нөхцөл, боломж бий болгоход оршино.<sup>1</sup>

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг 2016 онд баталж, хуулийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн эрхийг хүндэтгэн үзэж, тэдний бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн эрх, хүчирхийлэл дарамтаас ангид байх, хамгаалуулах эрхтэй холбоотой заалтуудыг тусгайлан нэмж өгсөн нь хамгийн онцлог бөгөөд сайшаалтай үйл явдал байсан. .

Хөгжлийн бэрхшээлтэй хүн бүр бусдын нэгэн адил хүний эрх, эрх чөлөөг ямар ч ялгаваргүй эдлэх явдлыг баталгаажуулах зорилгоор НҮБ-аас Оюуны хомсдолтой хүний эрхийн тухай /1971/ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай /1975/, Харааны болон сонсголын бэрхшээлтэй хүний эрхийн тухай /1979/ зэрэг тунхаглалуудыг батлан гаргасан байна. Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт “ Хүн бүр хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрхтэй, өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хөгжлийн бэрхшээлтэй болох зэрэг тохиолдолд төрөөс эд мөнгөний тусламж авах эрхтэй” хэмээн зааж өгсөн.<sup>2</sup>

Монгол Улсын хэмжээнд төр, хувь хүн, төрийн бус байгууллага, хуулийн этгээд, иргэд хоорондын харилцааг зохицуулан үйлчилж буй хүчин төгөлдөр нийт 92784 эрх зүйн акт байна. Үүнээс хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй холбоотой хүчин төгөлдөр үйлчилж буй дараах хууль тогтоомж байна. Олон улсын гэрээ 26, Хууль 76, Улсын Их Хурлын тогтоол 13, Үндсэн хуулийн цэцийн шийдвэр 3, Улсын дээд шүүхийн тогтоол 21, Засгийн газрын тогтоол 28 байна.

**Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй холбоотой Монгол Улсын хууль тогтоомжууд:**

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль 2016 он
2. Хөдөлмөрийн тухай хууль 1999 он
3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль 2011 он
4. Нийгмийн даатгалын тухай хууль 1994 он
5. Нийгмийн халамжийн тухай хууль 2012 он
6. Боловсролын багц хууль 2002 он
7. Барилгын тухай хууль 2016 он
8. Эрүүл мэндийн тухай хууль 2011 он

---

<sup>1</sup><https://gov.mn/wp-content/uploads/2015/06/CRPD>

<sup>2</sup>Б.Нармандах Хүний эрх УБ 2009 он 68 тал

9. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль 2015 он

10. Бусад холбогдох хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоол, Засгийн газрын холбогдох тогтоол, журам

**“Хөгжлийн бэрхшээлтэй хүн”** гэдэгт бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг хэлнэ<sup>1</sup>.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн \8-11\ зүйлд хөгжлийн бэрхшээлтэй хүний аюулгүй орчинд амьдрах эрхийг зааж өгсөн.

➤ Орон сууц, олон нийтийн барилга байгууламж, зам талбай, нийтийн тээвэр, мэдээлэл, харилцаа холбооны технологи нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байна.

➤ Нийтийн тээвэр, харилцаа холбоо, нийтийн үйлчилгээ, барилга байгууламжийг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй болгох, хиймэл эрхтэн, туслах болон асаргаа сувилгаа, ариун цэвэр-эрүүл ахуйн материал, хэрэгсэл, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, үйлчилгээ үзүүлж байгаа иргэн, хуулийн этгээдийг дэмжих хөтөлбөрийг Засгийн газар батална.

➤ Төрөөс хөгжлийн бэрхшээлтэй хүн дэд бүтэц, орон сууц, олон нийтийн барилга байгууламжид саадгүй хүрэх, тэдгээрийг чөлөөтэй ашиглах нөхцөлийг энэ хууль, хот байгуулалтын болон барилгын тухай хууль тогтоомжийн дагуу бүрдүүлэх ажлыг иргэн, хуулийн этгээдтэй хамтран зохион байгуулна.

➤ Нийтийн тээврийн байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй хүн нийтийн тээврийн хэрэгслээр чөлөөтэй зорчих нөхцөлийг бүрдүүлнэ.

➤ Мэдээллээр үйлчилдэг хуулийн этгээд нь өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэх явцад хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээлэл авах эрхийг хангах, техник, технологийн хэрэгсэл, бусадтай харьцах боломж, нөхцөлийг бүрдүүлнэ гэж хуульдаа эдгээр зүйлүүдийг зааж өгсөн боловч амьдрал дээр төдийлөн хэрэгждэггүй хуулийн заалтууд юм.

## **2.Эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх тэдгээрийг зохицуулж буй хуулийн хэрэгжилтийн өнөөгийн байдал**

Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтаар хүн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй болохыг тодорхойлсон. Үндсэн хуулийн энэ эрхийг хангах зорилгоор Монгол Улс иргэдийнхээ эрүүл, аюулгүй орчинд амьдрах

---

<sup>1</sup><https://www.legalinfo.mn/>

эрхийг улам бүр баталгаажуулах үүднээс олон улсын эрх зүйн баримт бичгүүдэд нэгдэн орох, түүнчлэн дотоодын эрх зүйн актуудад тухай бүр тусган баяжуулах арга хэмжээг тасралтгүй авч ирсэн. Хүн бүр хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс үл хамааран хууль, шүүхийн өмнө эрх тэгш байж, үндсэн эрх, эрх чөлөөгөө эдлэн, нийгмийн баялгаас адил хүртэх эрхтэй. Хүнийг хөгжлийн бэрхшээл болон эрүүл мэндийн байдлаар нь ялгаварлан гадуурхахыг хориглоно.

Өнөөгийн цаг үед хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх хууль ёсны ашиг сонирхол ихээхэн зөрчигдөж энэ нь хууль биеллээ олохгүй байгаатай холбоотой гэж үзэж байна. Хууль, эрх зүйн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн илэрхий гадуурхаагүй боловч тэдний оролцоонд учирч буй саадыг арилгахад чиглэсэн арга хэмжээ хангалтгүй байгаагийн улмаас эдгээр хүмүүс, ялангуяа төвөөс алслагдсан орон нутгийн иргэд нийгмийн бүхий л харилцаанд тэгш оролцож чадахгүй, далд алагчлалд өртсөөр байна. Жишээ нь: орон нутагт амьдардаг харааны бэрхшээлтэй иргэд мэдээлэл авах боломж туйлын хомс, мөн дэд бүтэц хүртээмжгүйгээс тэргэнцэртэй иргэд гэрээс гарах боломжгүй, гадуурхагдсаар бүхэл насаа гэртээ өнгөрөөж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хангаж, хамгаалах, ялангуяа тэдний оролцоог бодитоор хангах, хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, охидын эрх, түүний дотор тэдгээрийн нөхөн үржихүйн хүчирхийллээс ангид байх, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, сурч боловсрох эрхийн хэрэгжилтийг өргөжүүлэхэд чиглэсэн хүчин чармайлтаа 2 дахин нэмэгдүүлэх хэрэгтэй байна.

Миний бодлоор Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль нь бэхжээгүй дөнгөж л хөгжиж яваа хууль юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүн амьдрахад тохиромжгүй улсын нэг бол манай улс. Эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх өнөөдөр тэдний хувьд маш их зөрчигдөж байгаа юм.

Конвенцын ба Монгол Улсын хууль тогтоомжид тусгасан зарим зүйл заалтуудын хооронд багагүй зай завсар байгааг цохон дурдъя.<sup>1</sup>

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд:

Дараах дүрэм, журам, хөтөлбөрийг боловсруулж батлуулаад байна. Үүнд:

- “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрэм”-ийг Засгийн газрын 2016 оны 200 дугаар тогтоолоор;

---

<sup>1</sup><http://nli.gov.mn/wp-content/uploads/2018>

- “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд тусламж, хөнгөлөлт үзүүлэх журам”-ыг Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолоор;

- “Мэргэжлийн ур чадварын олон улсын тэмцээнд амжилттай оролцсон хөгжлийн бэрхшээлтэй хүнд урамшуулал олгох ба урамшуулал олгох журам”-ыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/212 дугаар тушаалаар;

- “Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээ”-ний стандарт боловсруулах салбар дундын ажлын хэсэг ажиллаж байна.<sup>1</sup>

**Хүргэмж:** Хуулийг хагас дутуу биелүүлж байгаа учраас хуулийн заалт ба бодит байдал зөрүүтэй байна.

**Бие даан амьдрах болон тухайн суугаа орчиндоо байх эрх:** Монгол Улсын хууль тогтоомж, бодлого нь хүн энгийнээр амьдарч үйлчлүүлэх эрхийг хязгаарлаж буйн улмаас энэ талаар суурь шинжтэй өөрчлөлтийн шалтгаан болж чадахгүй байна.

**Боловсрол:** Монгол Улсын Боловсролын тухай хуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурах, боловсрол олж авах эрхийг хамгаалсан тусгай зүйл байхгүй буюу хүүхдийн бүрэн чадамжийг хөгжүүлэхэд чиглэсэн заалт байхгүй байна.

**Ажил, хөдөлмөр эрхлэлт:** Монгол Улсын хууль тогтоомжоор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн мэргэжлийн сургалт, санал нэгдсэн ажиллагаа, ажлын байр хадгалах зэрэг асуудлаар тэгш, жигд арга хэмжээ авахгүй байна.

Засгийн газрын 2009 оны 26 дугаар тогтоолоор “Хөдөлмөрийн тухай” хуулийн 111 дүгээр зүйлд заасан хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулах квотыг хангаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас Хөдөлмөр, эрхлэлтийг дэмжих тусгай санд татан төвлөрүүлэх хөрөнгийн норматив хэмжээг тогтоосон нь эдгээр иргэдийг ажлын байраар хангах хариуцлагын чухал хөшүүрэг болж байна.

Сүүлийн 2 жилд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх зорилготой нийт 516 төсөл шалгаруулж, бүгд нэг тэрбум гурван зуу орчим сая төгрөгийн санхүүжилт хийж, үүний үр дүнд 1800 гаруй ажлын байр бий болсны 1130 орчимд нь

---

<sup>1</sup><https://www.mlsp.gov.mn/>

хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, бусдад нь тэдний гэр бүл, асран хамгаалагчид ажиллаж байна.<sup>1</sup>

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах зорилготой тусгай агентлагийг байгуулж дараах үүргийг хэрэгжүүлэх хэрэгтэй.

- Шүүхэд татах эрх эдлүүлэх, хууль зөрчсөн тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй хувь иргэнд давуу гарцтай нөхцөл бүрдүүлэх:

- Хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж, ноцтой зөрчлийг мэдээллийн дагуу авч хэлэлцэх, шийдвэр гаргах:

- Энэ талаар зохих байгууллагад хандах, бусад институттэй хамтран ажиллах:

- Эдгээр үүрэгтэй холбогдуулж эрх тэгш хөдөлмөр эрхлэх боломж олгох газар, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн газар зэргийн зайлшгүй бүтцийг бүрдүүлэх

### **3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийн хэрэгжилтийн хүрээнд тулгамдаж буй асуудал**

Монгол улсын иргэн бүр эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхтэй хэмээн хуульчилсан байдаг ч бодит байдал дээрээ энэхүү ойлголт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд хийсвэр ойлголт болсон байна. Учир нь эрүүл аюулгүй орчинд амьдрахын нэгэн бүрдүүлбэр нь нийгмийн бүхий л харилцаанд эрх тэгш, алагчлалгүй оролцох явдал.

Монгол улсын иргэн хүн бүр аль ч байдлаараа алагчлуулахгүй байх эрх зүйн үндэс нь Үндсэн хууль болон салбарын хуулиудад холбогдох заалтуудаар тусгагдсан байдаг бөгөөд шууд нэр зааж дурдаагүй ч нийтлэг хамрах утгаараа алагчлахын эсрэг заалт үйлчилж байгаа гэж үздэг. Гэвч нэр зааж өгөөгүй нь тухайн бүлгийг нийгмээс ангид байж тусгаарлагдах нэгэн үндэс болдог. Тухайлбал Үндсэн хуульд “Хүнийг үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно”<sup>2</sup> гэж заасны дотор бие эрхтэн, хөгжлийн онцлог гэсэн үг хэллэг бүхий нэр томьёо байхгүй байгаа нь бусад бодлого, хуульд болон нийгмийн харилцаа, үйл ажиллагаанд алагчлалыг өдүүлсэн болон өөгшүүлж байгаа явдал юм.

Хууль эрх зүйн хүрээнд энэхүү хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг илэрхий гадуурхаагүй ч тэдний нийгмийн оролцоонд учирч буй саадыг

---

<sup>1</sup><http://nhrcm.gov.mn/media/documents/>

<sup>2</sup>Монгол улсын Үндсэн хууль УБ.,1992он

арилгахад чиглэсэн арга хэмжээ болоод тухайн хуулийн заалтын хэрэгжилт хангалтгүй байгаагийн улмаас эдгээр хүмүүс нийгмийн бүхий л харилцаанд эрх тэгш оролцож чадахгүй далд алагчлалд өртсөөр л байна. Энэ нь хүний эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх зөрчигдөж байгаа явдлуудын наад захын жишээ болно. Монгол улсад нийтдээ 105730 хөгжлийн бэрхшээлтэй иргэн амьдардаг бөгөөд тэд бүгд нийгмийн харилцаанд эрх тэгш оролцдоггүй байна.<sup>1</sup>

Аюулгүй орчинд амьдрах боломжоор хангагдах асуудлын хувьд Монгол улсын зам тээвэр болоод барилга байгууламжийн зохион байгуулалтын хувьд энэхүү эрх нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд хангагддаггүй нь бидэнд өдөр бүр харагддаг.

Монгол улсын дээр дурдсан хууль тогтоомж, актуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах зорилгоор олон арга хэмжээг авч хэрэгжүүлсэн болон хуулийн заалтуудыг шинэчлэн тусгаж өгсөн ч бодит байдал дээр хэрэгжилт нь хангалтгүй байна.

#### **Жишээ нь:**

➤ Төмөр замын үйлчилгээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан налуу зам, лифт

➤ Авто тээврийн үйлчилгээнд тухайн бүлэгт зориулсан тэмдэг тэмдэглэгээ, тухайн хүмүүст зориулагдсан зориулалтын тээврийн хэрэгсэл зэрэг нь байдаггүй. Үүний улмаас хөгжлийн бэрхшээлтэй хүн тээврийн хэрэгслээр зорчих боломж нь хомс бөгөөд аюултай байдаг.

➤ Яаралтай тусламжийн үйлчилгээ авах тохиолдолд онцгой байдал, түргэн тусламж, цагдаагийн газарт дохионы хэлний орчуулагч ажилладаггүй нь энэ талын тусламж үйлчилгээ авах байдал нь хязгаарлагдаж байгаа.

➤ Үйлчилгээний байгууллагуудаар үйлчлүүлэхэд тэргэнцэртэй болоод харааны бэрхшээлтэй хүмүүст зориулсан тусгай зам байдаггүй, байсан ч хэлбэрийн төдий байгаа нь мөн л нийгмийн харилцаанд оролцож аюулгүй байдлаар хангуулах эрхийг нь зөрчиж байна.

Тиймд хууль эрх зүйн зохицуулалтыг бодит байдал дээр хэрэгжүүлэхийн тулд төрөөс тодорхой бүлэгт хандсан зохицуулалтыг нарийвчлан тусгаж өгөх шаардлагатай байна.

• Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, аж ахуй нэгжүүдэд иргэн бүрд тэгш хүртээмжтэй үйлчлэх боломжийг бүрдүүлэх тухай ажлыг явуулах. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгай зам, тэмдэг тэмдэглэгээ ашиглах, дохионы хэлмэрч ажиллуулах.

---

<sup>1</sup><http://www.1212.mn/>

- Авто Тээврийн үйлчилгээ явуулдаг бүхий л төрлийн тээврийн хэрэгсэлд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан шат болоод зохих хэсгийг гаргаж өгөх.

- Ил болон далд хэлбэрээр явагдаж буй алагчлалын тухай асуудлыг зохицуулахын тулд хууль эрх зүйн орчинд шинэчлэл хийх шаардлагатай.

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг харж асарч байгаа гэр бүлийн гишүүдийг мөн харгалзан үзэх ёстой бөгөөд тэдний тухайд мөн л эрх зүйн зохицуулалт шаардлагатай.

### **Дүгнэлт**

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудлаар мэргэжлийн чадамжтай судалгааны багуудаар нэлээд хэдэн судалгаа хийсэн нь өнөөгийн нийгэм дэх хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн аж байдал, ажил хөдөлмөр, сэтгэл санааны байдлыг илрүүлж тодорхойлоход шууд чиглэснээрээ үндэслэлтэй бодлого, арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлэхэд дөхөм болж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүн нийгэмшүүлэх, ажил хөдөлмөрөөр хангагдахаас илүү хувиараа хөдөлмөр эрхлэх нөхцөл бүрдэж байх тул албан тушаалын 4 буюу түүнээс дээш орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулаагүй тохиолдолд төлбөр авах тухай заалт үндсэн зорилгодоо хүрч чадаагүй. Өөрөөр хэлбэл, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажилтай байлгах аас илүү санд хөрөнгө төвлөрүүлэх заалт болсон тул үндсэн зорилгод хүрэх агуулгыг тусгасан зохицуулалт байх нь зүйтэй байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай хууль манай оронд бэхжээгүй байгаа юм. Хуулиар бүх эрхийн олгосон ч хөгжлийн бэрхшээлтэй бүх хүн эрх тэгш эрүүл аюулгүй орчинд амьдарч хөдөлмөрлөж чадахгүй байна.

Монгол улсын хувьд хөгжлийн бэрхшээлтэй 105730 хүн амьдардаг бөгөөд эдгээр иргэдийг асран хамгаалж, харж хандахын тулд суралцах, хөдөлмөрлөх, нийгмийн амьдралд бүрэн дүүрэн оролцож чадахгүй байгаа гэр бүлийн гишүүд, асран хамгаалагчдын тоог нэмбэл ойролцоогоор 400000 гаруй хүн хөгжлийн бэрхшээлээс үүдсэн асуудалтай амьдарч байгаа юм. Тиймд эдгээр бүхий л хүмүүсийг хамарсан цогц бодлогыг хэрэгжүүлэн нийгмийн бүхий л давхарт амьдардаг хөгжлийн бэрхшээлтэй болон түүний асран хамгаалагчид хүрч үйлчлэх нь эн тэргүүний асуудал болж байна.

### **Санал, зөвлөмж**

- Орон сууц, олон нийтийн барилга байгууламж, зам талбай, нийтийн тээвэр, мэдээлэл, харилцаа холбооны технологи нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байна гэж тодорхойлсон хууль тогтоомжуудын хэрэгжилтийг хянаж холбогдох байгууллагуудад чиг үүрэг өгч ажиллуулах

➤ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг бие даан амьдрахад туслах зорилгоор үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагааг чанаржуулж иргэдэд эрх тэгш үйлчлэх нөхцөлийн биелэлтийг бүрдүүлэх.

➤ Авто тээврийн үйлчилгээ явуулдаг бүхий л төрлийн тээврийн хэрэгсэлд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан шат болоод зохих хэсгийг гаргаж өгөх.

➤ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сурч боловсрох эрхийг нэн тэргүүнд хангаж өгөх, ингэснээр тэдний нийгэмд эзлэх боловсролын түвшин нэмэгдэж ажлын байранд эзлэх хувь нийгмийн оролцоо нь мөн адил нэмэгдэнэ.

---o0o---